



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/474

Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, "Макс Групп"-ийн ерөнхийлөгч, тод манлай уяач Дагвадоржийн Ганбаатарын "Хөдөлмөрийн баатар" цол хүртсэний хүндэтгэлийн наадмын арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ш.Насан	(аймгийн Засаг даргын Зөвлөх)
Гишүүд:	Д.Алтанзагас	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)
	М.Лхагвасүрэн	(Цагдаагийн газрын эрүүгийн тасгийн дарга)
	Ц.Лувсанжамц	(Онцгой байдлын газрын орлогч, Урьдчилан сэргийлэх тасгийн дарга)
	Э.Отгонбаатар	(Ардын дуу бүжгийн "Алтай" чуулгын дарга)
	Б.Баянзул	(Биеийн тамир, спортын газрын ахлах мэргэжилтэн)
	Б.Билэгдэмбэрэл	(Дэлхийн зөнгийн тусгай төслийн хөтөлбөрийн мэргэжилтэн)
	Н.Цээпилмаа	(Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн)
	Б.Бат-Эрдэнэ	(Баян-Уул сумын Засаг дарга)
Нарийн бичгийн дарга:	Г.Хурцгэрэл	(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

2. Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, "Макс Групп"-ийн ерөнхийлөгч, тод манлай уяач Дагвадоржийн Ганбаатарын "Хөдөлмөрийн баатар" цол хүртсэний хүндэтгэлийн наадмын арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулахыг ажлын хэсэг (Ш.Насан)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ